



IV-VI/2022

Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18



Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх улирлаас 13.6 хувиар өсжээ


Манай улсад 2022 оны 2 дугаар улирлын байдлаар гадаадын 88 улсын 6.2 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна.

Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 0.9 (18.0%) мянган хүнээр, өмнөх улирлаас 0.7 (13.6%) мянган хүнээр өссөн байна. Нийт гадаад иргэдийн 5.5 (89.2%) мянга нь эрэгтэй, 0.7 (10.8%) мянга нь эмэгтэй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй нийт гадаад иргэдийн 60.4 хувь нь БНХАУ-ын, 4.6 хувь нь БНЭУ-ын, 4.5 хувь нь Вьетнам Улсын, 4.3 хувь нь ОХУ-ын, 3.6 хувь нь БНСУ-ын, 2.9 хувь нь Австрали, 2.7 хувь нь АНУ-ын, 2.6 хувь нь Өмнөд Африк, 2.4 хувь нь Филиппин, 12.0 хувь нь бусад улсын харьяат байна.

Насны бүлгээр харьцуулбал хамгийн өндөр буюу 17.1-17.9 хувь нь 45-49, 50-54 насныхан, 14.6 хувь нь 35-39 насныхан, 14.3 хувь нь 40-44 насныхан байгаа бол хамгийн бага буюу 2.2 хувь нь 24 хүртэлх насныхан байна.

ЗУРАГ 1. АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ГАДААДЫН ИРГЭД, 2022 оны 2 дугаар улиралд, насны бүлгээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Ажил эрхэлж байгаа гадаад иргэдийн 2.3 (37.2%) мянга нь Улаанбаатарт, 2.2 (36.1%) мянга нь Төвийн бүсэд, 0.9 (14.7%) мянга нь Зүүн бүсэд, 0.4 (6.9%) мянга нь Баруун бүсэд, 0.3 (5.1%) мянга нь Хангайн бүсэд ажиллаж байна.

Боловсролын түвшнээр харьцуулбал 2.5 (41.0%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 2.3 (36.9%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 623 (10.0%) нь бүрэн дунд, 556 (9.0%) нь

тусгай мэргэжлийн дунд, 144 (2.3%) нь суурь, 48 (0.8%) нь магистр, докторын боловсролтой байна.


Ажил эрхэлж буй гадаад иргэдийн 2.6 (42.4%) мянга нь мэргэжилтэн, 1.5 (23.5%) мянга нь техникч болон туслах дэд мэргэжилтэн, 0.7 (11.2%) мянга нь менежер, 0.7 (11.2%) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, 0.5 (8.7%) мянга нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 0.1 (1.7%) мянга нь энгийн ажил, мэргэжил, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 53 (0.9%) нь контор, үйлчилгээний ажилтан, 29 (0.5%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 1 (0.02%) нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтнаар ажиллаж байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар



Манай улсад 2022 оны 2 дугаар улиралд ажил эрхэлж буй гадаад иргэдийн 2029 (32.7%) нь уул уурхай, олборлолтын, 1585 (25.5%) нь барилгын, 641 (10.3%) нь боловсруулах үйлдвэрлэлийн, 637 (10.3%) нь боловсролын, 410 (6.6%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 335 (5.4%) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 569 (9.2%) нь бусад салбарт ажиллаж байна. Өмнөх улиралтай харьцуулахад, тухайлбал барилгын салбарт 479 (43.3%) хүнээр өсөж, боловсролын салбарт ажил эрхэлж буй гадаадын иргэд 111 (14.8%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар



Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг ажиллаж буй байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 5.7 (91.1%) мянга нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 0.2 (2.8%) мянга нь төрийн бус байгууллагад, 45 (0.7%) нь төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 38 (0.6%) нь төсөвт байгууллага, 7 (0.1%) нь хувьцаат компани, 0.3 (4.7%) мянга нь бусад байгууллагад ажиллаж байна.

Ойлголт, тодорхойлолт:

- Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.
- Гадаад иргэдэд ажил эрхлэх үйлчилгээг "Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах" тухай хууль, Засгийн газраас тухай бүр батлан гаргадаг гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой тогтоол шийдвэрийн хүрээнд үзүүлдэг. "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 15.1.4, 8, 9-р заалтын дагуу "HG", "O" болон "SH" ангиллын визээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ болон уригч талын хөдөлмөрийн гэрээгээр ирсэн гадаадын иргэдэд ажил эрхлэх зөвшөөрөл олгож байна.
 - ❖ "HG" ангиллын визээр цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээгээр ирж ажиллана.
 - ❖ "SH" ангиллын визээр шашны байгууллагын урилгаар (i) цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид, (ii) цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.
 - ❖ "O" ангиллын визээр төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын урилгаар цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.



Эх үүсвэр:

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 10 дугаар сарын 14

Нийгмийн статистикийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн статистикч
Л.Даваажаргал
Утас : (976-51)-265543



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212